



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 6 сарын 07 өдөр

Дугаар 113

Улаанбаатар хот

Үнэт цаасны компаниудын үнэт цаасны зах зээлд
зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 406 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журам”-ын 8.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад нэр дурдсан 10 үнэт цаасны компанийн үнэт цаасны зах зээлд зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлөө арилгаж, энэ талаар Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдээгүй тохиолдолд үнэт цаасны зах зээлд зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авахыг хавсралтад нэр дурдсан үнэт цаасны компаниудын удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудад анхааруулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын албанд ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорвооны 2017 оны
6 дугаар сарын 27-ны өдрийн 119 дугаар
тогтоолын хавсралт



№	Компанийн оноосон нэр	Үйл ажиллагааны чиглэл
1	"Бага хээр ҮЦК" ХХК	Брокер, дилер
2	"Бумбат шигтгээ ҮЦК" ХХК	Брокер, дилер
3	"Догсон ҮЦК" ХХК	Брокер, дилер
4	"Превалент ҮЦК" ХХК	Брокер, дилер, андеррайтер
5	"Сэлэнгэ түмэн ҮЦК" ХХК	Брокер, дилер
6	"Финанс линк групп ҮЦК" ХХК	Брокер, дилер
7	"Говийн ноён нуруу ҮЦК" ХХК	Брокер, дилер
8	"Би Би Эс Эс ҮЦК" ХХК	Брокер, дилер
9	"Зюс капитал ҮЦК" ХХК	Брокер, дилер, хөрөнгө оруулалтын сан
10	"Эм Даблю Ти Эс ҮЦК" ХХК	Брокер, дилер